



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/16/НА-СТА-ОНӨ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Болдбаатар Утас: 70512127 Цахим хаяг: boldbaatarn@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал .....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
5.1 Төлбөрийн акт .....	12
5.2 Албан шаардлага .....	12
5.3 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

#### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ  
СУМЫН УРТЫН ГЭГЭЭ ОНӨААТҮГ-  
ЫН ЗАХИРАЛ Н.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2023.03.22 № 162  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Аймгийн 80 жилийн ойд зориулсан нийтийн эзэмшлийг гэрэлтүүлгийн ажил 30.0 сая, Одкон хотхоны 2-р байрны гадна фасадын засварын ажил 8.0 сая нийт 38.0 сая төгрөгийн ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 14 өдрийн А/494 тоот захирамжаар эзэмшил газрын хэмжээ өөрчлөн газар эзэмшүүлж, газар эзэмших эрхийг 1,989.100,0 мянган төгрөгөөр, Сүхбаатар аймгийн Баруун Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19 өдрийн 15/12 тоот тогтоолоор 186,048.7 мянган төгрөгийн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Уртын гэгээ” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн

D:/Bichig hereg/2023/A4 тоот

засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан боловч гүйцэтгэл, үр дүнг нь дүгнээгүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>120,512,131.67</b>	<b>142,143,745.54</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>26,769.10</b>	<b>3,286,138.31</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>26,769.10</b>	<b>3,286,138.31</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>26,769.10</b>	<b>3,286,138.31</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	26,769.10	3,286,138.31
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>27,347,653.57</b>	<b>27,978,987.91</b>
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	24,891,478.71	24,891,478.71
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,456,174.86</b>	<b>3,087,509.20</b>
33510	Байгууллагаас авах авлага	2,132,172.86	3,063,507.20
33520	Хувь хүмүүсээс авах авлага	324,002.00	24,002.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>24,856,640.00</b>	<b>0</b>
<b>34710</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	<b>24,856,640.00</b>	<b>0</b>
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	24,856,640.00	0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>16,931,069.00</b>	<b>110,878,619.32</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>16,931,069.00</b>	<b>110,878,619.32</b>
35470	Бусад хангамжийн материал	16,931,069.00	110,878,619.32
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>51,350,000.00</b>	<b>0</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	51,350,000.00	0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,865,524,806.94</b>	<b>4,583,787,379.98</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,865,524,806.94</b>	<b>4,583,787,379.98</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,865,104,806.94</b>	<b>2,576,145,879.98</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,443,839,723.10	4,317,424,423.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,763,893,703.58	-2,104,925,124.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,272,221.99	288,272,222.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,442,198.68	-68,531,995.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,661,480.00	205,716,480.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,391,981.10	-64,476,927.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,879,000.00	2,869,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-338,800.00	-617,450.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	519,065.21	519,065.21
39215	Хуримтлагдсан элэгдэл	0	-103,813.04
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>420,000.00</b>	<b>2,007,641,500.00</b>
39301	Програм хангамж	420,000.00	1,410,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	-232,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0	2,006,464,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,986,036,938.61</b>	<b>4,725,931,125.52</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,229,217,853.80</b>	<b>3,086,795,371.39</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,229,217,853.80</b>	<b>3,086,795,371.39</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>12,428,802.60</b>	<b>5,636,525.29</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	469,933.37
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>12,428,802.60</b>	<b>5,166,591.92</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	12,155,446.00	5,147,545.32
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	273,356.60	19,046.60
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>3,216,789,051.20</b>	<b>3,081,158,846.10</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	3,216,789,051.20	3,081,158,846.10
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>-243,180,915.19</b>	<b>1,639,135,754.13</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>-243,180,915.19</b>	<b>1,639,135,754.13</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-243,180,915.19</b>	<b>1,639,135,754.13</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-49,033,713.92	-243,180,915.19
51220	Тайлант үеийн үр дүн	-194,147,201.27	1,882,316,669.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,986,036,938.61</b>	<b>4,725,931,125.52</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>655,296,401.64</b>	<b>3,025,959,702.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>655,296,401.64</b>	<b>3,025,959,702.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>655,296,401.64</b>	<b>3,025,959,702.00</b>
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	655,296,401.64	1,036,859,702.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	1,989,100,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>849,443,602.91</b>	<b>1,143,643,032.68</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>849,443,602.91</b>	<b>1,143,643,032.68</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>849,443,602.91</b>	<b>1,143,643,032.68</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>849,443,602.91</b>	<b>1,143,643,032.68</b>
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	849,443,602.91	1,143,643,032.68
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-194,147,201.27</b>	<b>1,882,316,669.32</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-194,147,201.27</b>	<b>1,882,316,669.32</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-49,033,713.92	-49,033,713.92
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-49,033,713.92	-49,033,713.92
3	Тайлант үеийн үр дүн	-194,147,201.27	-194,147,201.27
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-243,180,915.19	-243,180,915.19
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-243,180,915.19	-243,180,915.19
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-243,180,915.19	-243,180,915.19
7	Тайлант үеийн үр дүн	1,882,316,669.32	1,882,316,669.32
8	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,639,135,754.13	1,639,135,754.13

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>588,154,500.00</b>	<b>1,036,859,702.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>588,154,500.00</b>	<b>1,036,859,702.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>588,154,500.00</b>	<b>1,036,859,702.00</b>
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	588,154,500.00	1,036,859,702.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>594,954,439.83</b>	<b>1,023,665,332.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>594,954,439.83</b>	<b>1,023,665,332.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>594,954,439.83</b>	<b>1,023,665,332.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>157,209,139.00</b>	<b>187,343,451.63</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	157,209,139.00	187,343,451.63
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,621,884.43</b>	<b>52,376,888.18</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	46,621,884.43	52,376,888.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,235,751.00</b>	<b>86,299,952.67</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	44,235,751.00	86,299,952.67
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>294,848,428.00</b>	<b>660,124,495.40</b>
210401	Бичиг хэрэг	3,425,110.00	0
210402	Тээвэр, шатахуун	11,146,086.00	47,643,920.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	669,622.00	0
210404	Ном, хэвлэл	5,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,773,000.00	0
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	18,610,166.00	0
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	254,219,444.00	612,480,574.75
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,261,800.00</b>	<b>0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	256,800.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,005,000.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>580,000.00</b>	<b>0</b>
210604	Урсгал засвар	580,000.00	0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>240,000.00</b>	<b>0</b>
210702	Дотоод албан томилолт	240,000.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,957,437.40</b>	<b>37,520,544.91</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,704,891.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,672,000.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,500.00	0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	153,260.00	0
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	12,849,661.40	19,912,757.91
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	136,125.00	1,251,850.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	2,371,000.00	16,355,937.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-6,799,939.83</b>	<b>13,194,369.21</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,694,700.00</b>	<b>9,935,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,694,700.00</b>	<b>9,935,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,694,700.00</b>	<b>9,935,000.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	3,694,700.00	9,935,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-3,694,700.00</b>	<b>-9,935,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-10,494,639.83</b>	<b>3,259,369.21</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,521,408.93	26,769.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,769.10	3,286,138.31

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн зорилго нь “Хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн тасралтгүй байдлыг хангах, иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг бүрэн хангах, оршин суугчдыг цэвэр орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх” зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд гэрэлтүүлэг засвар үйлчилгээ, зам талбай, хөшөө дурсгал, тоглоомын талбайн арчлалт, иргэдийн үйлчилгээ явуулах статустай байна.

#### **3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ статустайгаар орон нутгийн 100 хувийн өмчлөлтэй, Баруун-Урт суманд харьяалагдаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутаг хөгжүүлэх сан болон төсвийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан, хийж гүйцэтгэнэ.
- Баруун-Урт сумын гудамж, зам талбайн гэрэлтүүлэг түүний арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Баруун-Уртад байрлах хөшөө дурсгал, чийрэгжүүлэлтийн тоглоомын талбай, сурталчилгааны самбаруудын арчлалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангаж, засварлах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
- Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн засвар үйлчилгээ, орцны гэрэлтүүлгийн, ашиглалт хамгаалалт, бүрэн бүтэн найдвартай байдлыг хангах түүнийг зохион байгуулах үйл ажиллагааг явуулна.
- Орон сууцны гадна, доторх цэвэрлэгээ үйлчилгээг хэвийн ажиллагаатай байлгах, оршин суугчдын тав тухтай амьдрах боломжоор хангаж ажиллана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уртын гэгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,739,894.2 мянган төгрөгөөр буюу 36.8 өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26.8	3,286.1	3,259.3
Авлага	27,347.6	27,979.0	631.4
Бараа материал	68,281.1	110,878.6	42,597.5
Урьдчилж төлсөн зардал	24,856.6	-	-24,856.6
Үндсэн хөрөнгө	2,865,524.8	4,583,787.4	1,718,262.6
Нийт хөрөнгө	<b>2,986,036.9</b>	<b>4,725,931.1</b>	<b>1,739,894.2</b>
Өр төлбөр	12,428.8	5,636.5	-6,792.3
Урьдчилж орсон орлого	3,216,789.0	3,081,158.8	-135,630.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-243,180.9	1,639,135.7	1,882,316.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>2,986,036.9</b>	<b>4,725,931.1</b>	<b>1,739,894.2</b>

Харилцах дансны үлдэгдэл 3,286.1 мянган төгрөг болж 3,259.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэлд 27,979.0 мянган төгрөг болж 631.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татварын хэлтэс рүү хаоат-ыг илүү шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдэл 110,878.6 мянган төгрөг болж 42,597.5 мянган төгрөгөөр өссөн нь гудамж талбайн гэрэлтүүлгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор замын гэрэлтүүлгийн гэрлийн шон, гэрлийн толгойг зорилгоор худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үнэ төлбөргүй буюу шилжүүлэн авсан 2,487,612.7 мянга, худалдан авсан 9,935.0 мянга, нийт 2,497,547.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 38,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 225 дугаар албан бичгийн дагуу акталж, 312,464.0 мянган төгрөгийг хөрөнгийг нэр төрөл дотроо шилжүүлэн бүртгэсэн ба хөрөнгө элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 5,636.5 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 6,792.3 мянган төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уртын гэгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 1,143,643.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,154.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,008.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой холбогдох горим сорилыг хэрэгжүүлэхэд 6,883.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлээ.

Үүнд:

- Байгууллагаас тэтгэмж, урамшуулалд 4,833.1 мянган төгрөгийн олгосон. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь /хууль тогтоомжид

зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/ заалттай нийцэхгүй байна.

- Цахим дэлгүүрт байршсан зөөврийн болон суурин компьютерыг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 2,050.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалттай нийцэхгүй байна

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 орлогын, 2 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 14 гүйлгээг мэдээлээгүй байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймаг Уртын гэгээ ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	935.7	1	935.7	100
Албан шаардлага	3	29,373.7	3		50
Зөвлөмж	3	11,146.0	3	-	75
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>40,519.7</b>	<b>7</b>	<b>935.7</b>	

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 1,989.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,989.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

- Газар эзэмших эрхийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн.

Аудитаар нийт 36.4 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 32.4 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

#### 1. Илрүүлэлт

Хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтны цалингаас хүн амын орлогын албан татвар 335.6 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь / үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;/, 20.1.7 дахь /тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах/, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар 22.1 дэх /дараах орлогыг албан татвараас чөлөөлнө/ 22.1.2 дахь / хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого / заалттай нийцэхгүй байна

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

#### 2. Илрүүлэлт

Зарим ажилчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 3,619.8 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь / үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;/, 20.1.7 дахь /тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах/, 20.5 дахь /Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна./ заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоох

### 5.2 Албан шаардлага

#### 1. Илрүүлэлт.

Орон тоон батлагдаагүй албан тушаалын цалинг хавсран ажилласны нэмэгдэл 7,438.2 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь / үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;/, 20.1.7 дахь /тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах/, 20.5 дахь /Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна./ заалттай нийцэхгүй байна хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **2. Илрүүлэлт**

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй он дамжсан 24,981.5 мянган авлага бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;/ 20.2.5 /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах;/ 20.2.6/эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ заасан заалт болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

## **3. Илрүүлэлт:**

Жолоочийн замын хуудсанд спидометрийн заалтыг бөглөөгүй, гарын үсгээр баталгаажуулахгүй, холбогдох арга зүй, стандартын дагуу үнэн зөв хөтлөөгүй, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй, тээвэр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д / аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө/, 13 дугаар зүйлийн 13.1 /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7 /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;/ -д заасан заалт болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

## **4. Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 орлогын, 2 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 14 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

## **5.3 Зөвлөмж**

### **1. Тэтгэмж, урамшуулалттай холбоотой**

#### **Илрүүлэлт:**

Байгууллагаас 4,833.1 мянган төгрөгийн тэтгэмж, урамшуулал олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/ заалттай нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах.

### **2. Цахим худалдан авалттай холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Цахим дэлгүүрт байршсан зөөврийн болон суурин компьютерыг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 2,050.0 мянган төгрөгөөр худалдан авсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх

"Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Цахим дэлгүүрт байгаа бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Газар эзэмших эрхийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн</i>	1	1,989,100.0	-	-	1	1,989,100.0	1	1,989,100.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,989,100.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,989,100.0</b>	<b>1</b>	<b>1,989,100.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтны цалингаас хүн амын орлогын албан татвар суутгасан.	1	335.6	1	335.6	-	-	-	-	-	-	-	-
Зарим ажилчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон	1	3,619.8	1	3,619.8	-	-	-	-	-	-	-	-
Тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй он дамжсан авлага бүртгэлтэй байна.	1	24,981.5	-	-	1	24,981.5	-	-	-	-	-	-
Орон тоо нь батлагдаагүй албан тушаалын цалинг хавсран ажилласны нэмэгдэл олгосон	1	7,438.2	-	-	1	7,438.2	-	-	-	-	-	-
Тээвэр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>36,375.1</b>	<b>2</b>	<b>3,954.8</b>	<b>3</b>	<b>32,419.7</b>			<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 орлогын, 2 зарлагын гүйлгээ хоцроож мэдээлсэн, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 14 гүйлгээг мэдээлээгүй байна	1	-	-	-	1	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Цахим дэлгүүрт байршсан барааг авалгүйгээр бусад этгээдээс худалдан авсан.	1	2,050.0	-	-	-	-	1	2,050.0
Байгууллагаас тэтгэмж , урамшуулал олгосон.	1	4,833.1					1	4,833.1
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,883.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>6,833.1</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>6,833.1</b>			<b>1</b>		<b>2</b>	<b>6,833.1</b>